

## **МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ШИНЭ ПАРАДИГМ**

*Д.Уламбаяр\**

### **Удиртгал**

Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод орчин маш хурдан өөрчлөгдөж байна. Тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

Эдүгээ олон улсын хамтын ажиллагааны хамгийн чухал зүйл нь олон улсын эрхзүйн хэм хэмжээнд дэлхийн улс орнуудын тогтвортой байдлыг хангах, олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц нөхцөл байдлыг хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна. Хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Украины хямралын үндсэн шалтгаан нь Орос, ЕХ-ны хооронд стратегийн тэнцвэр, ашиг сонирхлын тэнцвэрийг барьж чадаагүйд оршино. Тийнхүү бие биенийхээ эрх ашигт хэрхэн нөлөөлөхгүй байх тухай асуудал чухал болов.

Улс орнуудын өмнө дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохоос гадна, даяаршиж буй дижитал ертөнцөд дасан зохицох, түүнчлэн олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журамд хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна.

---

\* Д.Уламбаяр. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал, профессор, доктор Ph.D

Олон туйлт дэлхийн шинэ бодлогын үзэл санаа анхлан 1997 оны 4 дүгээр сарын 23-нд Москвад гарын үсэг зурсан «Олон туйлт ертөнц, олон улсын шинэ дэг журмыг цогцлоон байгуулах тухай Орос-Хятадын хамтарсан тунхаглалд»<sup>1</sup> тусгалаа олсон юм. Энэхүү үзэл санаа ШХАБ, БРИКС-ийн орнуудын дээд уулзалтын баримт бичгүүдэд тусгалаа олсоор ирэв.

ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров Монгол Улсын ГХЯ-нд хийсэн уулзалт дээр тэмдэглэхдээ: “Дэлхий ертөнц өнөөдөр түүхэн шинэ эрин үед шилжин орох үе шатандаа ирээд байна. Энэ бол бидний хийж буй ул суурьтай дүгнэлт юм. Өнөөдөр олон улсын харилцааны олон төвт бүтэц бий болж байна. Сүүлийн жилүүдэд өрнөж буй үйл явдлууд нь нэг туйлт ертөнц бий болгох оролдлого хийгээд дэлхий дахинд ганцаар давамгайлах хүсэл эрмэлзэл нь төөрөгдөлд хүргэдэг болохыг харуулж байна. Өнөөгийн нөхцөл байдалд дэлхийн аль ч улс орон, хамгийн хүчирхэг нь байлаа ч тэр, хэсэг бүлэг орнууд байгаад ч тэр орчин цагийн тулгамдсан асуудлуудыг дангаараа үр дүнтэйгээр шийдвэрлэх гэж оролдоод ч нэмэргүй нь илт болжээ. Ийм нөхцөл байдал үүссэн үед бүгдэд тулгарч буй асар том сорилт хийгээд аюул заналд оновчтой хариу барих үүднээс дэлхийн тавцан дахь үндсэн гол тоглогчдын жинхэнэ бодитой түншлэлд тулгуурлан үндэсний эрх ашиг болон хамтын дипломат үйл ажиллагааны хоорондох ухаалаг тэнцвэрийг эрж хайх нь чухал боллоо”<sup>2</sup> гэжээ.

Бид олон улсын харилцааны олон туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицож, урагш алхах шаардлагатай.


### ***Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигм:***

Монгол Улсын гадаад бодлогын параметрийг макро судалгааны түвшинд авч үзвэл Монгол Улсын гадаад бодлогын шинэ парадигмыг дараах байдлаар томъёолж байна. Гадаад бодлогын парадигм гэдэг нь түүний хэв шинжийг тодорхойлж байгаа хэрэг юм.

<sup>1</sup> Российско-Китайская совместная декларация о многополярном мире и формировании нового международного порядка. Москва, 23 апреля 1997 года (текст документа с изменениями и дополнениями по состоянию на ноябрь 2007 года)

<sup>2</sup> Выступление и ответы на вопросы Министра иностранных дел России С.В.Лаврова на встрече в МИД Монголии, Улан-Батор, 14 апреля 2016 года

1. Монгол Улсын гадаад бодлогын шинэ зарчим: Үндэсний язгуур эрх ашгийг дээдэлсэн, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, эвсэлд үл нэгдсэн, бие даасан (New Principles of Mongolia's Foreign Policy: Priority of Vital National Interests, Openness, Peaceful Nature Policies, Multiples-Pillars of Policy, Non-Alignment and Independent Nature of Policy);
2. Хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харьцах (Balanced Partnership Relations with its Neighbors);
3. Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй бүсийн статус (Mongolia's International Security and Nuclear-Weapon-Free Status);
4. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого (Mongolia's «Third Neighbor» Policy);
5. Монгол Улсын гурвалсан хөршийн бодлого буюу саммит (Mongolia's Trilateral Neighborhood Policy)
6. АСЕМ-11 Улаанбаатарын дээд түвшний уулзалт (11<sup>th</sup> ASEM Ulaanbaatar summit) эдгээр болно.



Одоо дээрх асуудлуудыг нэг бүрчлэн авч үзье.

**Монгол Улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл:**

Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй сэргэн мандаж буй гүрэн бол, урд хөрш дэлхийн хамгийн олон хүн амтай, цөмийн зэвсэгтэй, үсрэнгүй урагшилж буй эдийн засагтай хамгийн том хөгжиж буй орон, мөн хоёул өөрсдийн бие даасан бодлого, байр суурьтай их гүрнүүд юм. Монгол Улс ийм өвөрмөц геополитикийн байршилтай *singularcountry* гэж хэлж болно.

Тиймээс Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 онд ОХУ-тай *“Сайн хөршийн уламжлалт түншлэл”*, 2009 онд *“Стратегийн түншлэл”*, 2003 онд БНХАУ-тай *“Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл”*, 2011 онд *“Стратегийн түншлэл”*, 2014 онд *“Иж бүрэн стратегийн түншлэл”*-ийн харилцааны эрхзүйн үндсийг тавьсан нь нэн чухал ач холбогдолтой байсан бөгөөд энэ нь “гурвалсан хөршийн бодлого” хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал угтвар нөхцөл байв.

“Түнш”, “түншлэл” хэмээх нэр томъёо нь 1990-ээд оны эхнээс олон улсын харилцааны хэллэгт бодлогын шинжтэй, шинэ агуулга, хэлбэртэйгээр баттай орж ирэв. Өнөөдөр “стратегийн түншлэл”, “иж бүрэн стратегийн түншлэл”, “энхийн төлөө түншлэл”, “гуравдагч хөрш”, “иж бүрэн түншлэл”, “түншлэл, хамтын ажиллагаа”, “хөгжлийн түншлэл”, “оюун санааны хөрш” буюу түншлэл, “өргөн хүрээтэй түншлэл”, “өргөтгөсөн түншлэл”, “бүх талыг хамарсан түншлэл”, “олон талтай хамтын ажиллагааны түншлэл”, “тэгш эрхтэй түншлэл” гэх зэрэг нэр томъёо нь олон улсын харилцааны баримт бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээл зэрэгт өргөн дэлгэр тусгагдаж, мөн улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид сайхь нэр томъёог өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс нарийн ширийн шигтгээ оруулан үйл явцын өрнөлтөд тохируулан тайлбарласаар байна.

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх

ашиг, сонирхолыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа төлөв тодорхойлж байна. Тэгэхлээр түншлэл нь “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд “иж бүрэн” байж болно, “стратегийн” байж болно, “олон талтай”, эсвэл “өргөн хүрээтэй” байж болно, мөн “оюун санааны” түншлэл байж болно. Өөрөөр хэлбэл, хоёр тал ямар бодол, сонирхолтой байгаагаасаа хамааран түншлэлийн харилцаагаа янз бүрээр тодотгож, томъёолон гаргаж ирж байгаа ч утга агуулга нь хоорондоо адил төстэй юмуу, ижил байдаг. Зарим орон “стратегийн” гэдэг үгнээс зайлсхийдэг. “Стратегийн түншлэл”-д уламжлалт болон уламжлалт бус аюул, аюулгүй байдлын цогц асуудал, батлан хамгаалах, энхтайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, сайн засаглалын асуудал гол төлөв тусгагдсан байдгаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд тогтвортой үргэлжилнэ гэсэн санаа хамт явж байдаг байна. Харин энд “холбоотны буюу эвслийн” эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, “ах дүүгийн” харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулгад суурилдаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээлгэдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм. Зарим судлаачид холбоотны харилцааны ХХI зууны өөрчлөгдсөн хэлбэр нь *стратегийн түншлэл* гэж бичсэн нь ч буй.

Зарим улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг журам бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй. *Даяаршлын одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлж байна.* Нөгөө талд Монгол Улсын орон зайн байршил, байгалийн баялаг хоёр геополитикийн гол хүчин зүйл болов.

2011 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 14.1-г: *“ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны*

*бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ*” гэж заасан нь 1994 оны заалтыг дахин нотолсон хэрэг юм. Харин “*Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана*”<sup>3</sup> гэсэн өмнөх баримтлалын заалтыг хэвээр үлдээсэн нь тэнцвэртэй харилцах бодлоготой зөрчилдөж болохуйц санаа гэж ойлгогдож байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс 2002 онд ОХУ-тай 3543 км урт хилийг хамтран шалгаж эцэслэн тодотгосон бол, 2001-2004 онд БНХАУ-тай хилээ хоёрдахь удаагаа хамтран шалгаж, 4676.8 км урт хилийн шугамыг тогтоож, Монгол Улсын хилийн багануудыг анх удаа боржин чулуугаар шинэчлэн босгов. Ийнхүү өнөөдөр Монгол Улсын хилийг эмжсэн 8219 км 895 м урт хил олон улсын гэрээ, хэлэлцээрээр баталгаажсан нь тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгаа болж байна.

### **Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого:**

1990-ээд оны эхнээс Монгол Улсын гадаад бодлогод “гуравдагч хөрш”, “гуравдагч хөрш”-ийн бодлогын үзэл санаа буй болж, эдүгээ тухайлсан төрийн бодлого хийгээд онол-практикийн түвшний судалгааны шинэ чиглэл болов. Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа, холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай болон эдийн засгийн уламжлалт ойлголт улам бүр харилцан хамааралтай даяаршсан эдүгээ үед үндсээрээ шинэчлэгдсээр байна гэдгийг энд онцлон тэмдэглэх ёстой.

Аливаа улс орон өөрийн үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар хангахын тулд тусгайлан томъёолсон гадаад бодлого, дипломат ажиллагааг эрхлэн явуулж, тэр нь олон улсын дэмжлэг хүлээж байсан нь цөөнгүй. Үүний тод жишээ нь 1988 онд тунхагласан БНСУ-ын Ерөнхийлөгч Но Тэ-Үүгийн (Roh Tae-woo) “Northern diplomacy” юм. Сайхь бодлогын

<sup>3</sup> Монгол Улсын гадаад бодлогын хөх ном: 2007-2011, ГХЯ, УБ., 2011, 114 дэх тал

мөн чанар нь Хойд Солонгосын хамгийн ойрын холбоотон коммунист орнуудтай дипломат харилцаа тогтоож, олон улсын харилцаанд өөрийн улс төрийн байр сууриа бэхжүүлэх, улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засагт хэрэгцээтэй түүхий эд, борлуулалтын болон санхүү, худалдаа-хөрөнгө оруулалтын шинэ зах зээл нээх, НҮБ-д БНАСАУ-тай нэгэн зэрэг гишүүнээр элсэх (гол нь НҮБ-ын АЗ-ын Байнгын гишүүн ЗХУ, БНХАУ-ын байр сууриас шалтгаалан дангаараа элсэх боломжгүй байв), Хойд Солонгосыг нээлттэй болгох, үндэсний нэгдлийг хэрэгжүүлэхэд оршиж байв. АНУ-ын Ерөнхийлөгч том Ж.Буш, Зөвлөлтийн удирдагч М.С.Горбачёв нар сайхь бодлогыг бүрэн дэмжсэн юм. “Умардын бодлого”-ыг социалист орнууд, түүний дотор Монгол Улсын тухайн үеийн удирдагчид нааштайгаар хүлээн авч, дипломат харилцаа тогтоох санаачилгыг анхлан гаргаж байв. Монгол Улсын “гуравдагч хөрш» -ийн бодлого БНСУ-ын “Умардын бодлого”-той олон талаараа адил төстэй. Дээрх бодлогоос хойш 10 жилийн дараа 1998 онд Ерөнхийлөгч Ким Дэ-жүнь (Kim Dae-jung) “Sunshine policy” буюу “Нарны илч”-ийн бодлогыг тунхагласан нь “Умардын бодлого”-ын үргэлжлэл байсан гэж үздэг. Энэхүү бодлогын үр дүнд 2000 онд хоёр Солонгосын удирдагчдын дээд уулзалт зохиогдож, Ким Дэ-жүнь энхтайвны салбарт Нобелийн шагнал хүртсэн билээ.

БНМАУ, ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоосны эх сурвалж нь аанай л Холбооны канцлер, социал-демократ Вилли Брандтын явуулсан “Ostpolitik” буюу “Дорнодын бодлого”-той юуны өмнө холбоотой байв. Герман нь Солонгосын адил дэлхийн II дайны дараа хоёр хуваагдсан билээ. “Ostpolitik”-т ЗХУ-ын нөлөө туссан хэдий ч Вилли Брандт тууштай прагматик бодлого явуулж, ХБНГУ “Бүх Германыг төлөөлөх цорын ганц улс” гэсэн зарчмаасаа татгалзаж, 1970 онд ХБНГУ ба ЗХУ, ХБНГУ ба БНПАУ-ын гэрээнд гарын үсэг зурж, уг гэрээнд Европ дахь хил хязгаар, түүний дотор Одер-Нейсийн хил, ХБНГУ, БНАГУ-ын хоорондын хилийг халдашгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээ 1972 оны 6 дугаар сарын 3-наас хүчин төгөлдөр болжээ. ХБНГУ нь Чехословак, Болгар, Унгартай харилцаагаа хэвийн болгож, дипломат харилцаа тогтоон, Баруун Берлиний асуудлаар дөрвөн гүрний хэлэлцээр байгуулж, улмаар 1973 онд хоёр Герман НҮБ-д адил тэгш эрхт хууль ёсныхоо суудлыг эзэлсэн нь “Ostpolitik”-ийн гол үр дүн байв.

Улмаар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Хельсинкийн Төгсгөлийн баримт бичигт Европын хил хязгаарын халдашгүйг нотлон Европын 33 орон (Албаниас бусад) болон АНУ, Канад гарын үсэг зурсан юм. “Ostpolitik” ХБНГУ-ын үндэсний язгуур эрх ашигт бүрнээ нийцсэн юм. Европ тивд буй болсон намжмал байдлын нааштай уур амьсгал БНМАУ, ХБНГУ-ын хооронд 1974 оны 1 дүгээр сарын 31-нд дипломат харилцаа тогтоох үндсэн нөхцлийг бүрдүүлжээ. Дипломат харилцаа тогтоох санал, санаачлага ХБНГУ-ын талаас гарсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд сайхь үйл явц 1973 онь 5 дугаар сараас хоёр талын Лондон хотноо эхэлсэн зургаан удаагийн яриа хэлэлцээрийн үр дүн байв. “Дорнын бодлого”, “Умардын бодлого”, “Гуравдагч хөрш”-ийн бодлогын нийтлэг үндэслэл нь хүчний тэнцвэр юм.

Ер нь аливаа улс орны хувьд хөршүүд гэдэг нь ямагт чухал үүрэгтэй байдаг бөгөөд тухайн орны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход үлэмж чухал нөлөө үзүүлдэг.

Дипломатын түүхэнд “Гуравдагч хөрш”, түүнд хандсан бодлогын асуудал ямагт байсаар ирсэн бөгөөд эдүгээ ч ач холбогдлоо алдаагүй гэдгийг мөн адил онцлон тэмдэглэх хэрэгтэй. Аль нэгэн бага буурай улс хоёр их хүчний шахалт, заналхийлэл, бүр түрэмгийлэлд өртөж тусгаар тогтнолоо алдах, газар нутгаа булаалгах асуудалтай тулгарахдаа гуравдагч хүчний ивээл тусламжийг эрэн хайж байсан баримт олон улсын харилцаа, дипломатын түүхэнд цөөнгүй байсан юм.

“Гуравдагч хөрш” хийгээд “Гуравдагч хөрш”-ийн бодлого хэмээх ухагдахуун нь Монгол зэрэг хоёр их гүрний дунд орших, цэрэг-эдийн засгийн чадамж сул, хүн ам бага улсад юуны түрүүнд хамаарах, үндэсний аюулгүй байдлаас үүдэн гарсан бодлогын асуудалтай холбоотой. Гэхдээ олон улсын харилцаа, дипломатын түүхэнд “гуравдагч хүчин”-ийг хайсан баримтуудаас харахад зөвхөн хоёр улстай хиллэдгээс шалтгаалан гардаг ойлголт, бодлогын асуудал гэж үзэж хараахан болохгүй юм.

XIX зууны сүүлчээр тухайн үедээ Сиам гэж нэрлэгдэж байсан өнөөгийн Тайландын Вант улсад Бирмийн талаас Их Британи нөлөөгөө ихэсгэж, Энэтхэг-Хятадын хойгоос Франц санаархаж тус улсын бие даасан байдалд аюул занал учрахад Вангийн ордныхон цэрэг-эдийн

засгийн хүчин чадал бүхий, тухайн үедээ Зүүн Өмнөд Азид язгуур ашиг сонирхолгүй байсан Хаант Орост хандаж дипломат дэмжлэг эрэн хайсан баримт байдаг.

1962 оны Карибын тэнгисийн пуужингийн хямралын үед Кубад хийгээд Вьетнамын дайны үед тухайн улсад нэг ёсондоо ЗХУ “гуравдагч хөрш” нь байсан гэж хэлж болохоор байдаг. Үүний уг сурвалж нь АНУ-тай сөргөлдөж байсан хүйтэн дайны үед Америкийн бөөрөнд болон Энэтхэг, Хятадын хойгт ЗХУ-ын асар том ашиг сонирхол байсанд оршино. Ер нь АНУ тэргүүтэй Өрнөдийнхэнтэй сөргөлдөж байсан хэнтэй боловч дотносох нь ЗХУ-ын гадаад бодлогын чухал чиглэл болж байв. Эндээс харахад бага жижиг улс “гуравдагч хөрш” хэмээн найдаж буй улсдаа хандахад тухайн “гуравдагч хөрш” нь тус бүс нутагт өөрийн цэрэг-улс төр, эдийн засгийн томоохон ашиг сонирхолтой байх явдал чухал юм. АНУ-ын хувьд ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж буй улс орнуудтай түншлэл, стратегийн харилцааг хөгжүүлэх нь гадаад бодлогынх нь тэргүүлэх зарчим байдаг. АНУ тэдгээр орнуудыг улс төр-дипломатын аргаар дэмжиж, эдийн засгийн тусламж үзүүлдэг. “Гуравдагч хөрш” нь цэрэг-улс төр, эдийн засгийн хүчин чадавхтай, ардчилсан дэглэмтэй, олон улсын харилцаанд нөлөө үзүүлж чадахуйц глобал бодлого явуулж буй улс гүрнүүд байх нь гарцаагүй. “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь юуны өмнө бага жижиг улс орнуудад хамаатай гэдэг нь тодорхой.

Улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалд “гуравдагч хөрш”-ийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор хараахан гараагүй байгаа юм. Энэ утгаараа Монгол Улс бага, жижиг орны гадаад бодлого дахь “гуравдагч хөрш” хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлого хэмээх шинэ ухагдахууныг буй болгон хэрэгжүүлж байгаа нь улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалын судлагдахууныг баяжуулж буй хэрэг гэж үзвээс зохилтой. Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уяалдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт шинэчлэгдэж байгаатай сайхь бодлого холбогдоно гэдгийг дээр тэмдэглэсэн.

1994 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш” хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлого, түншлэлийн талаар тусгайлан заагаагүй боловч 2010 онд шинэчлэн батлагдсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ”<sup>4</sup>, харин 2011 онд шинэчлэн батлагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “АНУ, Япон, Европын Холбоо... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх”-ээр<sup>5</sup> анх удаа бодлогын хэмжээнд тус тус заажээ. Харин шинэчлэн батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д Европын Холбооны Д.У талаар заагаагүй байна. Үзэл баримтлалаас харахад Монгол Улсын “гуравдагч хөрш” гэдэгт *нэгд*, өндөр хөгжилтэй, *хоёрт*, ардчилсан улс, холбоо гэж ойлгогдож байгаа юм. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээ гэдэгт улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг хэлж байна.

Бидний хувьд Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийг илүү өргөн утгаар нь авч үзвэл олон улсын энхтайван, аюулгүй байдлыг сахин хангах, нийт хүн төрөлхтний өмнө тулгамдсан нийтлэг асуудлыг авч хэлэлцдэг, хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ ч орох учиртай. НҮБ бол хөгжиж буй улс орнуудын нийтлэг эрх ашгийг илэрхийлдэг, мөн хамгаалдаг, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлдэг, Монгол Улс ч тэр, АНУ ч тэр хоёул адилхан нэг, нэг саналтай ийм түгээмэл байгууллага болой.

Монгол Улсын ГХЯ Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь биеэ даасан үзэл баримтлал байх ёстой гэж үзэж 2003 онд өөрийн саналыг ҮАБЗ-д оруулж байсан бөгөөд түүний гол үзэл санаа нь шинэчлэгдсэн Гадаад болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндсэндээ тусгагджээ.

<sup>4</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ.: 2010

<sup>5</sup> Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ.: 2011

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь тус улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэсэн, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл юм.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд хэрэг дээрээ “гуравдагч хөрш”-тэй болж, түүний эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой “Иж бүрэн түншлэл”, 2010 онд “Стратегийн түншлэл”, 1999 онд БНСУ-тай “Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл”, 2006 онд “Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл”, 2011 онд “Иж бүрэн түншлэл”, 2004, 2005 онд АНУ-тай “хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэл”, 2004 онд Канадтай “Өргөн хүрээтэй түншлэл”, 2005 онд Турк улстай “Иж бүрэн түншлэл”, 2007 онд Австрали улстай “Өргөтгөсөн түншлэл”, 2007 онд Казахстантай “Өргөн хүрээтэй түншлэл”, 2008 онд ХБНГУ-тай “Иж бүрэн түншлэл”, 2011 онд “Стратегийн түншлэл”, 2009 онд Энэтхэгтэй “Иж бүрэн түншлэл”, 2015 онд “Стратегийн түншлэл”, 2011 онд “Стратегийн түншлэл”, Украинтай “Олон талтай хамтын ажиллагааны түншлэл”, 2013 онд ЕХ-той “Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

“Гуравдагч хөрш”-ийн тухай ойлголт нь шинэ тутам гарч ирсэн үзэл санаа биш юм. Монгол Улс түүхэндээ “гуравдагч хөрш”-өө эрж хайж байсан цаг үе ХХ зууны эхний 20-иод жилд холбогддог бөгөөд харин ингэж цэгцтэй ойлгох, бодлогын түвшинд томъёолох талаар оролдлого хийж байгаагүй нь мэдээж.

“Аливаа улсын гадаад бодлого нь оршин буй газар зүйгээрээ тодорхойлогдоно” гэж Наполеон Бонапарт хэлжээ. Энэ үг газарзүйн онцлог байршилтай Монгол Улсад ихээхэн хамаатай.

“Гуравдагч хөрш”-ийн бодлого гэдэг нь зөвхөн газарзүйн бодлого, ойлголт бус, тухайлсан нэг улсад хандсан бодлого ч бус, харин улс төр, эдийн засаг, геополитик, аюулгүй байдлын хүрээг хамарсан газарзүйн байршил, орон зайн онцлогоос үүдэн гарсан олон улсын харилцааны онолын ухагдахуун хэмээн үзвээс зохистой. Цэрэг-эдийн засгийн

чадамж сул, хүн ам бага Монгол Улсын хувьд хөрш гүрнүүдээс явуулж буй бодлого, үйл ажиллагааны төвд зохистой хүчний тэнцвэрийг урт удаан хугацаанд хангах, хадгалах, саармагжуулахад чиглэгдсэн үндэсний аюулгүй байдлаас шууд үүдэн гарсан хөгжиж буй бага жижиг улсад хамаатай геополитикийн бодлого бөгөөд Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн бодлогыг тууштай дэмжигч Өрнө, Дорнын ардчилсан, хөгжингүй орнууд болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектыг оруулж буй өргөн хүрээтэй ойлголт гэж тодорхойлж болохоор байна.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, мөн зөвхөн энхтайван цагийн геополитик гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

“Гуравдагч хөрш”-ийн бодлогын онолын үндэс нь хүчний тэнцвэр (balance of power) болон ашиг сонирхлын тэнцвэр (balance of interests) болно. Ер нь хүчний тэнцвэрийн тухай үзэл санаа бүр 1713 оны Утрехтийн (Treaty of Utrecht) энхийн гэрээнд анх тусгагдсаныг энд тэмдэглэх хэрэгтэй. Гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл юм.

Монгол Улсын “гуравдагч хөрш”-ийн бодлого нь тус улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл юм.

АНУ-ын элчин сайд Жонатан Эдлтон *«Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, 1987-2012»* сонирхолтой бүтээлдээ: “Дотоод асуудал дээр ам хэлээр тохиролцож, заримдаа ширүүн мэтгэлцдэг ч гадаад бодлогын асуудлаар дэлхий нийтэд нэгдмэл байр сууриа харуулахыг хүсч буй Монголын улс төрчид үндэсний хэмжээний зөвшилцөлтэй байх хүнд ачааг зайлшгүй үүрч байна. Монгол Улсын гадаад бодлого дахь одоогийн чиг хандлагаас харахад хөрш хоёр оронтойгоо бат бэх харилцааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ томъёолол болох гуравдагч хөршөө олон янзаар хайж байна. Монгол Улс үүнийг илүү амжилттай хийх тусам цаашид улам амаргүй болж болох юм. Олон улсын тавцанд Монгол Улс ерөнхийдөө нэр хүнд сайтай байгаа нь энэ үйл явцыг илүү хялбар болгоход тус

дөхөм болно”<sup>6</sup> гэсэн анхаарал татсан дүгнэлт хийсэн байдаг.

Гэхдээ Монгол Улсын байнга төвийг сахих гадаад бодлогын санаачилга нь олон тулгуурт гадаад бодлогын зарчимтай зөрчилдөж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

### **Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статус:**

1992 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 48 дугаар чуулганы индэр дээрээс Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрээ цөмийн зэвсгээс ангид бүс болгож буйгаа зарласан билээ. 1998 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 53 дугаар чуулганаар “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус”-ын тухай 53/77/б тоот тогтоолыг Монгол Улс анх батлуулж, түүний мөрөөр цөмийн зэвсэггүй статусаа дотооддоо эрхзүйн талаас бататгаж, “Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын хуулийг 2000 оны 2 дугаар сард УИХ баталсан байна. Монгол Улс цөмийн зэвсэггүй статусаа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар 2000 оноос хойш 2 жил тутамд амжилттай хэлэлцүүлж, батлуулж ирсэн байна. Мөн олон талт хамтын ажиллагааны баримт бичгүүд болон хоёр талын хамтарсан мэдэгдлүүдэд Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг дэмжсэн заалт тусгалаа олсоор ирэв.

Энэ нь Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломатын аргаар хангахад чиглэсэн чухал арга хэмжээ байв. Цөмийн зэвсэгтэй таван гүрнээс 2000 онд Монгол Улсад олгосон цөмийн аюулгүй байдлын баталгааны агуулгыг Монгол Улс өөрийн геостратегийн өвөрмөц байршлын онцлогтойгоо нягт уялдуулсан шийдвэр гаргуулж, чингэсний дараа түүнийг олон улсын хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай байсан юм.

P5 (five Permanent member of the UN Security Council) гэж нэрлэгддэг НҮБ-ын АЗ-ийн Байнгын тав буюу цөмийн зэвсэгтэй таван гүрэн БНХАУ, БНФУ, ОХУ, Англи, АНУ-ын Байнгын төлөөлөгчид (Li Baodong, PRC, Gerard Araud, France, Vitaly I. Churkin, RF, Mark Lyall Grant, the United Kingdom of Great Britain and the Northern Ireland, Susan E. Rice, US) “Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх

---

<sup>6</sup> Addleton Jonathan S. A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012, p. 161

хамтарсан Тунхаглал”-д, Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгч О.Оч энэ статусын агуулгыг тодорхойлсон Тунхаглалд 2012 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Нью-Йорк хотноо НҮБ-ын Төв байранд тус тус гарын үсэг зурав. Энэ арга хэмжээнд Монгол Улсаас Австри Улсад суугаа элчин сайд, дээрх асуудлын Монголын талын зохицуулагч Ж.Энхсайхан мэдэгдэл хийж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг төлөөлж НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Ян Элиасон (Jan Eliasson) нар байлцжээ. Английн Байнгын төлөөлөгч P5-ын нэрийн өмнөөс энэхүү арга хэмжээг нээж үг хэлэхдээ: Цөмийн зэвсгээс ангид Монгол Улсын статусын талаарх P5-ын хамтарсан Тунхаглал болон Монгол Улсын Тунхаглал нь дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсан, цөмийн зэвсэгтэй гүрнүүд цөмийн зэвсэггүй орнуудтай хэрхэн хамтран ажиллах боломжтойг харуулсан, цөмийн зэвсгийг хорогдуулах үйлсэд хувь нэмэр оруулж байгаагаараа ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэсэн байна. P5 гаргасан хамтарсан Тунхаглалдаа Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын тухай хуулийг сайшаасан тухайгаа анх удаагаа албан ёсоор мэдэгдсэн бөгөөд тэд Монгол Улсын статусыг хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаанд оролцохгүй, тийм үйл ажиллагаа явуулахгүй байх амлалтыг Монголын талын саналаар тунхаглалд тусгасан байна. Монгол Улс нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласны 20 жилийн ой 2012 оны 9 дүгээр сард тохиож, энэ үеэр P5 Монголын энэхүү өвөрмөц статусыг бүрэн хүлээн зөвшөөрөн хүндэтгэж, түүнийг зөрчих аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх амлалт авсан нь улс төр-дипломатын нэн чухал ач холбогдолтой үйл явдал болсноос гадна, P5 тодорхой асуудлаар нэгдмэл байр суурьтай байгаагаа дэлхий дахинд харуулсан нь ч чухал болсныг НҮБ-ын ЕНБД-ын орлогч Ян Элясон (Jan Eliasson) тэмдэглэсэн юм.

Монгол Улсаас санаачлан 2012 оны НҮБ-ын ЕА-н 67 дугаар чуулганд өргөн барьсан “Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус” тогтоолын төслийг чуулганы улс төр, аюулгүй байдлын асуудлаарх 1 дүгээр хорооны 11 дүгээр сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, нийтийн зөвшилцлөөр, санал хураалтгүйгээр баталжээ. Дээрх мэдэгдлийг сайхь тогтоолд сайшаасан нь чухал ач холбогдолтой болов. Монгол Улсаас санаачилсан тогтоолыг Австрали,

АНУ, Их Британи, БНХАУ, ОХУ, Франц, Мексик, Марокко улс хамтран зохиогчоор оролцов.

*Монгол Улсын энэхүү туршилага Солонгосын хойгийг ирээдүйд цөмийн зэвсгээс ангид бүс болгох, Хойд Солонгос үндэсний аюулгүй байдлаа хангах хэрэгт чухал туршилага болох боломж байгааг тэмдэглэмээр байна.*

Эдүгээ Монгол Улсын цөмийн зэвсэггүй бүсийн статусын асуудлаар Р5-ын амлалтыг олон улсын гэрээний хэлбэрт оруулах асуудал чухал болой.

### **Монгол Улсын гурвалсан хөршийн бодлого:**

Монгол Улс гурвалсан яриа хэлэлцээний байнгын институцитэй болох чиглэлд анхны алхам хийсэн нь хөрш хоёр гүрний бодлого, байр суурийг илүү тодорхой ойлгож мэдэх, өөрийн улсын бодлого, байр суурийг илүү ойлгомжтой тайлбарлаж, дэмжлэг авах, гурван улсын эдийн засгийн хамтын ажиллагааны үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд нэн ач холбогдолтой.

Хөрш гурван улсын ГХЯ-д хоорондын 8 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Улс төрийн газрын захирал нарын түвшинд 2012 оны 10 дугаар сард Москва хотноо болсныг энд тэмдэглэх хэрэгтэй. Анх удаагаа албан ёсны статустайгаар болсон гурван талын зөвлөлдөх уулзалт цаг хугацааны сорилтыг амжилттай давж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны харилцан сонирхсон асуудлыг хэлэлцэх зохистой талбар болсон хэмээн талууд санал нэгтэй үзсэн юм.

Монгол Улс гурван хөршийн саммитыг санаачлан хэрэгжүүлж, энэ нь цаашдаа байнгын механизм болон төлөвшиж байна. 2014 онд Душанбе, 2015 онд Уфа, 2016 онд Ташкентэд амжилттай зохион байгуулагдав. Өөрөөр хэлбэл гурван улсын харилцаа шинэ агуулга, хэлбэрээр баяжин урагшилж байна. 2016 оны 6 дугаар сард Ташкентэд зохиогдсон ОХУ, Монгол, Хятад гурван хөршийн дээд уулзалт хамтын ажиллагааны “эдийн засгийн коридор хөтөлбөр”-ийг батлав. Гэхдээ Монгол Улсын санаачлагаар эхэлсэн гурван хөршийн саммитын агуулга нь цаашдаа зөвхөн хөрш хоёр гүрний худалдаа-эдийн засгийн бодлогод Монгол Улсыг хэрхэн яаж оролцуулах асуудлыг хэлэлцдэг

механизм байж таарахгүй нь мэдээж төдийгүй, улам өргөн хүрээтэй асуудал хэлэлцдэг байх шаардлагатай нь харагдаж байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Орос-Хятадын харилцаа иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрч, түүнчлэн БНХАУ-ын удирдлага Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн. Иймд өнөө болон ойрх ирээдүйн Монгол Улсын геополитик, гео-эдийн засгийн хамгийн ойр орчинд нэн таатай нөхцөл бүрдээд байна.

Саяхан Монгол, Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр болон “МонРосцветмет” нэгдлийн 49 хувийг эзэмшиж байсан оросын “Ростех” корпораци өөрийн эзэмшлийн бүх хувьцааг монголын хувийн хэвшлийн олонд танил биш нэгэн компанид заржээ. Тийнхүү эдүгээ тавь, тавин хувийн эзэмшилтэй “Улаанбаатар төмөр зам”-ыг эс тооцвол Монгол Улс дахь Оросын гео-эдийн засгийн том ашиг сонирхол үгүй болсон гэж үзэж болохоор байна.

XX зууны тэргүүн хагаст Монгол Улсын олон улсын эрхзүйн статусыг их гүрнүүд хүлээн зөвшөөрч, тус улс үндэстэн улс болох зам дээр эргэлтгүй гарч ирсэн билээ. Гол нь гадаад хүчин зүйлээс шалтгаалж, Монголчуудын тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд баталгаажуулах хүчин чармайлт XX зууны туршид үргэлжилжээ. Гол учир шалтгаан нь Алс Дорнод дахь олон улсын харилцааны өрнөл, Монгол Улсын газарзүйн байршил, их гүрнүүдийн геополитиктой шууд нөхцөлдсөнтэй холбоотой байв. Энэхүү цоо шинэ орчинд Монгол Улсын орчин цагийн дипломат алба өргөн бэхжиж, өөрийн улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө явуулсан тэмцэл Умард хөршийн геополитиктой нийцсэн байна.

Туурга тусгаар бүрэн эрхт Монгол Улсын Өмнөд хөрштэй харилцаагаа тогтоон хөгжүүлэх үйл явц тус улсын XX зууны гадаад харилцаа, дипломатын түүхэн дэх хамгийн ярвиг түвэгтэй асуудал байв. Үүнд саад болж байсан хүчин зүйлүүдийн гол учир нь Монгол-Оросын харилцаан дахь Хятад, Орос-Хятадын харилцаан дахь Монгол, Монгол-Хятадын харилцаан дахь Орос гэгчлэн харилцан хамааралтай боловч, эрс тэс ялгаатай эрх ашиг, сонирхол хосолсон гурвалжин бий болсон явдал юм. Энэхүү эрх ашиг, сонирхол нь *нэгд*, хэзээ ч Хятадын

бүрэлдэхүүн хэсэг байгаагүй туурга тусгаар Монгол Улсын хууль ёсны бүрэн эрхт байр суурь, *хоёрт*, Монголыг халхавч, бамбай байлгах гэсэн Хаант Орос, дараа нь ЗХУ-ын империйн хэдийнээс баримталж ирсэн геополитик, *гуравт*, Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж үзэж байсан Өмнөд хөршийн илэрхий бусармаг явуулга, байр суурь байв. Энэхүү гурвалжинд Японы хүчин зүйл тодорхой байр суурь эзэлж байсан юм. *Эцэст нь*, дурдсан гурвалжинд нөлөө үзүүлж байсан голлох оролцогч нь АНУ байсан гэдгийг тэмдэглэвэл зохино.

Дэлхийн II дайны дараа хоёр хөрштэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн төлөвийг нээсэн чухал үйл явдлын нэг нь гурван хөршийн хамтын ажиллагааны эхлэл тавигдсан явдал юм. Энэ нь ЗХУ, БНХАУ-ыг БНМАУ-ын нутгаар холбосон төмөр зам тавьж, ашиглалтад оруулахтай холбогдсон хэлэлцээр байгуулахаар гурван улсын удирдагчид 1952 оны 9 дүгээр сарын 15-нд Москвад дээд хэмжээнд уулзсан явдал байв. Дурьдсан хэлэлцээрт БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Жоу Энълай, ЗСБНХУ-ын СнЗ-ийн орлогч дарга бөгөөд ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский нар гарын үсэг зурж, И.В.Сталин тэргүүтэй Зөвлөлтийн удирдагчид байлцжээ. Энэ бол гурван хөршийн анхны саммит байв. Дурьдсан хэлэлцээрээр Улаанбаатар-Замын-Үүд-Жининий хооронд төмөр зам барихаар тохиролцож, бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж эхэлжээ. 1955 оны 12 дугаар сарын 31-нд Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замыг нээх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатарт болж, 1956 оны 1 дүгээр сарын 1-нээс ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа нээсэн тухай дэлхийн улс орнуудад зарлан тунхагласан байна. 1956 оны 1 дүгээр сарын 3-нд Монгол Хятадын хил дээр төмөр замыг холбосон мөнгөн хадаасыг хадах ёслолын ажиллагаа болж, БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, ЗХУ-ын Зам харилцааны сайд Б.П.Бещев, БНХАУ-ын Зам харилцааны сайд Тэнь Дэ Юан нар оролцож байжээ.

**АСЕМ 20 жил:**

АСЕМ 20 жил Монгол Улсын гадаад бодлого - дипломатын түүхэнд чухал үе шат болж, түүний хэв шинжийг бодитой илэрхийлсэн үйл явдал гэж дүгнэж болохоор байна. 2016 оны 7 дугаар сарын 15-16-нд АСЕМ-ын дээд түвшний 11 дэх уулзалт Улаанбаатар хотноо анх удаагаа өндөр дээд түвшинд амжилттай зохион байгуулагдав. Энэ жил АСЕМ-ын түүхэн хөгжлийн 20 жилийн ой тохиож байгаа нь энэхүү дээд уулзалтын онцлог болов. Монгол Улс 2006 онд Хельсинк хотноо зохиогдсон АСЕМ-ын дээд түвшний 6 дахь уулзалтаар гишүүнээр элсч, 2008 онд Бээжин хотноо зохиогдсон АСЕМ-ын дээд түвшний 7 дахь чуулга уулзалтаас хойш үйл ажиллагаанд нь тогтмол оролцож ирсэн бөгөөд 2014 онд Италийн Милан хотноо болсон АСЕМ-ын дээд түвшний 10 дугаар уулзалтаар Монгол Улс дараагийн уулзалтыг зохион байгуулах эрхийг авсан байна.

**“АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө”** сэдвийн дор зохион байгуулагдсан энэхүү дээд уулзалтад АСЕМ-ын гишүүн 51 орон, үүнээс Европын 30, Азийн 21 орон, хоёр олон улсын байгууллагаас өндөр түвшний төлөөлөгчид оролцов. Төрийн тэргүүний түвшинд нийт 10 орны Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, Засгийн газрын тэргүүний түвшинд нийт 23 орны Ерөнхий сайд, Шадар сайд, түүнчлэн 17 орны Гадаад хэргийн сайд болон бусад сайд, тусгай элч, элчин сайд нар Монгол Улсад хүрэлцэн ирсэн байна. Мөн ЕХ-ны Зөвлөлийн Ерөнхийлөгч, ЕХ-ны Комиссын Ерөнхийлөгч, АСЕАН-аас Ерөнхий нарийн бичгийн дарга хүрэлцэн иржээ. Нийт 4000 төлөөлөгчид оролцсон нь Улаанбаатар хотод болж буй АСЕМ-ын дээд уулзалтад хэр зэрэг өндөр ач холбогдол өгч байгааг харуулсан тод жишээ болов.

АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг сурвалжлахаар гадаадын 612, дотоодын 124 сэтгүүлч ажилласан байна. Харин хурлын үйл ажиллагаа болон бусад дагалдах арга хэмжээг Европын өргөн нэвтрүүлгийн холбоо, Монголын 14 телевиз хамтран газар дээрээс нь шууд дамжуулав. Эхний хэлэлцүүлэг нь *“Түншлэлийн 20 жил: Өнгөрснөө дүгнэж, ирээдүйгээ тодорхойлох нь”* сэдвийн хүрээнд болж, АСЕМ-ын түнш орнуудын төрийн тэргүүн нар сүүлийн 20 жилийн улс төрийн хэлэлцээ, эдийн засгийн хамтын ажиллагаа,

соёл-нийгмийн солилцоо, хамтын ажиллагаагаа дүгнэж ярилцжээ. Уулзалтад оролцогчид мөн АСЕМ-ын дараагийн арван жилийн төлөвлөгөө, төсөөллийн талаар санал солилцсон байна. Хоёрдугаар хэлэлцүүлэг нь **“АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө”** АСЕМ-ын түншлэлийг хөгжүүлэх өргөн уялдаа холбоо” сэдвээр чуулж, Ази-Европын “зөөлөн” болон “хатуу” уялдаа холбоог хөгжүүлэхэд илүү төвлөрч ярилцав. Эдгээр хоёр сэдэв бүхий хэлэлцүүлгээс гарсан санал дүгнэлтийг төгсгөлийн баримт бичгүүдэд тусган, батлахаар болсон байна.

АСЕМ-ын дээд түвшний 11 дэх уулзалтын 2 дахь өдрийн хуралдаан АСЕМ Вилла хотхонд “АСЕМ-ын гурван тулгуурыг өргөжүүлэх нь” сэдвийн дор үргэлжилж, *Улаанбаатарын Тунхаглал: “Ази-Европын уулзалт гурав дахь арван жилдээ”, Хурал даргалагчийн Мэдэгдэл: АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоотой байж ирээдүйн төлөө түншлэх нь”* хоёр баримт бичгийн хэлэлцэн батлав. АСЕМ дээд түвшний 12 дахь удаагийн уулзалтыг 2018 онд ЕХ-ны төв байрладаг Бельгийн нийслэл Брюссель хотноо зохион байгуулахаар болов.

Хоёр өдөр үргэлжилсэн дээд түвшний уулзалтын үеэр хоёр талын 160 гаруй удаагийн уулзалт зохион байгуулагдаж, гадаадын төр засаг, гадаад хэргийн сайд нарын хоорондын хоёр талт уулзалтуудыг амжилттай зохион байгуулахад бүх талын нэн таатай боломж олгосонд эрхэм хүндэт зочид талархлаа илэрхийлсэн юм.

Олон талт дипломат ажиллагааны тод илрэл болсон АСЕМ-ын дээд түвшний 11 дэх уулзалтыг Монгол Улс анх удаагаа өндөр хэмжээнд зохион байгуулж, аюулгүй байдлыг маш сайн хангасаныг зочид төлөөлөгчид өндөр үнэлсэн юм. Энэ удаагийн Улаанбаатарын дээд уулзалт нь ХБНГУ-ын Канцлер Ангела Меркелийн хэлснээр 100 жилд ганц тохиох алтан боломж болж байв.

АСЕМ-11 дээд уулзалтыг Монгол Улс нийслэл Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан нь Монголын дипломатын түүх төдийгүй Монголын түүхэнд тэмдэглэгдэх хосгүй үйл явдал болов.

АСЕМ-ын 11 дэх удаагийн Улаанбаатарын дээд хэмжээний уулзалтын өмнө 2016 оны 4 дүгээр сарын 21-22-нд Ази-Европын

парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалт, 5 дугаар сарын 12-13-нд АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт, 6 дугаар сарын 9-10-нд АСЕМ-ын Сангийн сайд нарын 12 дугаар уулзалт, 6 дугаар сарын 20-21-нд Ази-Европын хүнсний аюулгүй байдал, фермерийн уулзалт, 7 дугаар сарын 1-2-нд Ази-Европын иргэний нийгмийн 11 дүгээр уулзалт, 7 дугаар сарын 6-7-нд АСЕМ-ын Залуучуудын чуулган, 7 дугаар сарын 9-10-нд Ази-Европын Редакторуудын дугуй ширээний 8 дугаар уулзалт, 7 дугаар сарын 12-14-нд АСЕМ-ын Ахлах албан тушаалтнуудын уулзалт, 7 дугаар сарын 13-14-нд Ази, Европын Бизнесийн 15 дугаар чуулга уулзалт тус тус амжилттай зохион байгуулагдсан юм.

**Монгол Улс байнга төвийг сахих статусын талаарх нэгэн зүйл:**

Монгол Улсын байнга төвийг сахих санаачилга нь гадаад бодлогын шинэ парадигм болж чадахгүй гэдгийг юуны өмнө тэмдэглэмээр байна.

Монгол Улс байнга төвийг сахиж үл болох зарим учир шалтгааны талаар зохиогч байр сууриа урьд нь илэрхийлж байсан болно.<sup>7</sup>

Монгол Улсын байнга төвийг сахих санаачилгын талаар АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн Улаанбаатарын дээд уулзалтад оруулсан хурал даргалагчийн мэдэгдлийн төсөлд: “...Итгэлцлийг бэхжүүлэх, зуучлах олон улсын хамтын нийгэмлэгийн хүчин чармайлтад хувь нэмэр оруулахаар гаргаж буй байнга төвийг сахих санаачилга дахь Монгол Улсын хүчин чармайлтыг сайшааж байна”<sup>8</sup> гэсэн байна. Харин дээд уулзалтын 2 дахь өдрийн үдээс хойш хурлаар эцэлж, батлан гаргасан Хурал Даргалагчийн мэдэгдэлд: Тэд итгэлцлийг бэхжүүлэх арга хэмжээ нь энх тайван, тогтвортой байдлыг хангах үйлсэд чухал хувь нэмэр оруулж буйг тэмдэглэж, үүнтэй холбоотойгоор төвийг сахисан улс орнуудын хүч чармайлтыг ч мөн дурдав”<sup>9</sup> гэсэн байна. Өөр нэг зүйлийг дурвал:

<sup>7</sup> Д.Уламбаяр. “Байнга төвийг сахих үйл ба Монгол Улсын гадаад бодлогын сорилт”-Монгол Улс байнга төвийг үл сахих нь. УБ.: 2016, 3-34 дэх тал, Д.Уламбаяр. “Олон туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицох нь буюу байнга төвийг үл сахих учир шалтгаан”-“Зууны мэдээ” сонин, 2016.05.120, №93 (5279) Д.Уламбаяр. “Монгол Улс байнга төвийг сахих Ерөнхийлөгчийн санаачилга, хоёр хөршийн хандлага”-“ОХУ, БНХАУ-2015” судалгааны уулзалтын эмхтгэл. УБ.: 2016, 57-71 дэх тал

<sup>8</sup> 11<sup>th</sup> ASEM Summit “20 Year of ASEM5 Partnership for the Future through Connectivity”. CHAIR’S STATEMENT. Brussels, 5 July 2016 10689/16 p. 21

<sup>9</sup> АСЕМ-ын дээд түвшний 11 дэх удаагийн уулзалт. “АСЕМ-ын 20 жил: Уялдаа холбоогоор өртөөлөн ирээдүйн түншлэлийн төлөө” УБ.: 2016, 9 дэх тал

- Хоёр хөршийн судлаачид Монгол Улсын байнга төвийг сахих санаачилгыг АНУ-ын заавраар хийгдэж буй үйлдэл байж магад хэмээн болгоомжилсон дүгнэлт санаа ОУМЭ-ий их хурлын үеэр хөрш орнуудын тавьсан илтгэлд хийх хандлага ажиглагдаж байгаа нь анхаарах асуудал мөн.<sup>10</sup>

Монгол Улсын байнга төвийг санаачилга нь гадаад бодлогын шинэ парадигм болж чадахгүй гэдгийг юуны өмнө тэмдэглмээр байна. Тиймээс Монгол Улс байнга төвийг сахиж үл болох зарим учир шалтгааны талаар бодлоо хэлье.

Байнга төвийг сахих гадаад бодлого нь зөвхөн дайн, энхийн асуудал, их гүрнүүдийн аюулгүй байдлын бодлого, дарамт шахалт, нөлөөллийн бодлоготой холбогдолтойгоор шууд үүдэн гарч иржээ.

Монгол Улс байнга төвийг сахих тухай хууль санаачлан боловсруулж, энэ талаар Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, Гадаад бодлогын үзэл баримтлалд өөрчлөлт оруулж, түүнийгээ хөрш хоёр гүрэн болон олон улсад ухуулан ойлгуулах гэж байгаа нь бодлогын хийгээд зарчмын том өөрчлөлт гэж ойлгож байна. **Гадаад бодлогыг хуулиар зохицуулдаггүй.** Учир нь тухайн улсын хууль тухайн улсын нутаг дэвсгэр дээр л хүчин төгөлдөр үйлчилдэг. Тэгвэл гадаад бодлого нь олон улсын харилцаа, их гүрнүүдийн бодлого, байр суурь, хүчний хуваарилалт, геополитикийн орчны өөрчлөлтөөс шууд хамаардаг. Монгол Улс “байнга төвийг сахих” тухай ойлголтыг өөрсдийн хуулиар тайлбарлаад олон улсын эрхзүйд нэгэнт тогтсон заншлын хэм хэмжээг өөрчилж үл чадна. Хамгийн гол нь байнга төвийг сахих статус нь олон улсын харилцаа, дэлхийн хөгжлийн чиг хандлага биш болсоор удаж байгаад оршино.

Гадаад бодлогыг хэлбэржүүлэх тухай олон улсын харилцааны онолын ойлголт гэж байдаггүй. Монгол Улсын гадаад бодлогын зорилго, зорилт, зарчим, тэргүүлэх чиглэл хийгээд “гуравдагч хөрш”-ийн бодлого, бусад чиглэл, нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалах зэрэг өргөн хүрээтэй асуудлууд үзэл баримтлалд тусгагдсан. Одоогийн Монгол Улсын гадаад бодлого “хэлбэржээгүй” биш, харин ч маш сайн “хэлбэржсэн” гадаад бодлого мөн. Тэр нь үндэсний язгуур

<sup>10</sup> Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ивээл дор “Тогтвортой хөгжил ба Монгол судлал” сэдэвт олон улсын монголч эрдэмтдийн их хурал. Илтгэлийн товчлолууд. УБ.: 2016

эрх ашгийг дээдэлсэн, нээлттэй, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, эвсэлд үл нэгдсэн, бие даасан гадаад бодлого болно.

Монгол Улсын байнга төвийг сахих хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Байнга төвийг сахих” гэж аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй, энхийн цагт цэргийн эвсэл, холбоонд нэгдэхгүй байхыг хэлнэ” гэжээ. “Байнга төвийг сахих” гэдгийг бид хэрхэн ойлгож, түүнийг хуульчлан тодорхойлж, тайлбарлахаас илүүтэй олон улсын эрхзүй, олон улсын харилцааны онолд юу гэж авч үздэг, гадаадын улс төрчид, судлаачид, олон улс энэ талаар юу гэж ойлгодог вэ гэдэг хамгийн чухал. Олон улсын эрхзүйгээр зохицуулагдаагүй ч олон улсын эрхзүйн заншлын хэм хэмжээгээр зохицуулагдах зүйл гэж буй. Олон улсын эрхзүйчид, судлаачид энэ ойлголтыг сонгодог утгаар нь тайлбарлаж, Швейцарь улсыг жишээ болгох нь буй. Өргөн утгаар нь авч үзвэл олон улсын харилцааны практикт *“байнга төвийг сахих” гэдэг нь аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй, энхийн цагт цэргийн эвсэл, холбоонд нэгдэхгүй байх төдийгүй, “байнга” гэдгийн хамгийн гол агуулга нь цэрэг-улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талт хамтын ажиллагаанд оролцохгүй, олон улсын харилцаанд өрнөж буй аливаа асуудал, үйл явдлын талаар ямар нэгэн байр суурь илэрхийлэхгүй байх явдал юм.* Монгол Улс аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, зэвсэг, техник хэрэгсэл буцалтгүй тусламжаар авах, олон улсын хамтарсан цэргийн хээрийн сургууль хийх, бүс нутгийн болон олон улсын тулгамдсан асуудлыг хөндсөн хоёр улсын хамтарсан мэдэгдэл гаргах, цөмийн болон баллистик пуужингийн туршилтын талаар байр сууриа илэрхийлсэн мэдэгдэл гаргах, зэвсэгт хүчин нь НҮБ-ын мандатайгаар дайнд оролцох, стратегийн түншлэлийн асуудлыг огт үл хөндөхөөр бол энэ нь сонгогдог утгаараа “байнга төвийг сахих статус” байж чадахгүй юм.

Байнга төвийг сахих нь ганцаараа оршин тогтнохгүй. Эсрэг тэсрэг байр суурьтай хоёр ба түүнээс дээш сөргөлдөгч гүрнүүд, дайгагч талууд байж, тэдний хооронд дайн, зэвсэгт мөргөлдөөн гарах аюул, магадлал байнга байсан тул гуравдагч улс дайны үед ч, тайван үед ч байнга төвийг сахих шаардлага гарч иржээ. Тиймээс аливаа дайн

биш, харин өөрийн оршин буй геополитик, газарзүйн хамгийн ойр орчинд болзошгүй дайнд байнга төвийг сахиж ирсэн байна. Ази болон Америк тивд гарч болох дайнд ер нь бол хамааралгүй байв. Жишээ нь: Палестин, Израиль, Сирийн иргэний дайн, Украины Донбасс, Армен, Азербайжаны Уулын Карабах дахь зэвсэгт мөргөлдөөнд бид төвийг сахих шаардлага байхгүй. Швейцарийн түүх чухамхүү тийм байсан агаад Швейцарийн өвөрмөц байдал давтагдашгүй бөгөөд “Швейцарь лугаа төвийг сахиж хөгжсөн” улс байхгүй юм. ЕХ-ны зарим орнуудын төвийг сахих статустай болоход ЗХУ-ын нөлөө гол үүрэг гүйцэтгэсэн байна.

Дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ оршин тогтнож буй өнөө үед дайн, тэгэх тусмаа цөмийн дайн, дэлхийн дайн гарах магадлал харьцангуй бага байгаа юм. Хүйтэн дайны үед ч тийм байсан, харин бүс нутгийн хэмжээний дайн, зэвсэгт мөргөлдөөн гарвал хэнээс, хаанаас гэдэг нь эдүгээ маш тодорхой болсон. Хариуцлагагүй төр засаг, тоталитар болон авторитар дэглэмтэй улс, олон улсын террористууд л дайн, зэвсэгт мөргөлдөөнийг өдөөнө. Орчин үеийн олон улсын эрхзүй түрэмгий дайныг хориглосон учир өөрийгөө хамгаалахаас бусад зорилгоор дайн өдөөх нь олон улсын эрхзүйг зөрчсөн гэмт үйлдэл гэж үздэг. Тиймээс орчин үед аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцох, оролцохгүйн тухай, төвийг сахих, эс сахих тухай асуудал ерөнхийдөө утга чанараа алдсан байна. Цөмийн дайнд төвийг сахина гэж бүрч байхгүй. Энэ бол нийт хүн төрөлхтний эсрэг, хүний эрх, үндсэн эрх чөлөө, ардчилалын эсрэг хийж буй гэмт үйлдэл мөн. Дайн түрэмгийллий нөхцөлд Монгол Улс байнга төвийг сахиж сууж, хувиа хичээх нь нийт хүн төрөлхтний хамтын үнэт зүйлсээс татгалзсан хэрэг, хамгийн наад зах нь ёсзүйгүй үйлдэл юм. Бид хамтын үнэт зүйлс, энхтайван, шударга ёсыг эрхэмлэгч дэвшилт хүчинтэй эв санааны нэгдэлтэй байх ёстой болов уу. Терроризмын бүх хэлбэрийн эсрэг дайнд бид нэгдсэн билээ.

Солонгосын хойгийн аюулгүй байдал Монгол Улсад шууд болон шууд бусаар нөлөөлөхөөр байна. Солонгосын хойгийн хурцадмал байдал ноцтой даамжирч дайн, зэвсэгт мөргөлдөөн гарсан тохиолдолд Өмнөд Солонгост ажиллаж, сурч, амьдарч буй 30 гаруй мянган монгол иргэдийн аюулгүй байдлын асуудал шууд хөндөгдөнө. Зөвхөн тэдгээр

иргэд жилд дунджаар 90-100 сая ам. долларыг (2014 оны байдлаар дэлхийн хэмжээнд 583 тэрбум ам.доллар гуйвуулсан байна) эх орон руугаа гуйвуулдаг гэж тооцож үзэхэд ямар олон айл, гэр бүлийн амьдрал, бизнес, Монгол Улсын нийгэм-эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлж буй нь тодорхой. Дээрх тохиолдолд Монгол Улс төвийг сахиад сууж байж таарах уу.

Байнга төвийг сахихаа хуульчлан зарласан улсын сүүлчийн, гэхдээ муу жишээ нь Туркменистан юм. Туркменистаны байнга төвийг сахих статус нь тус орныг олон улсын хамтын ажиллагаа, үйл явдлаас хөндийрүүлж, зожигорход хүргэж, улмаар НҮБ-ын хүрээнд хамгийн идэвхгүй улс болгож, энэ нь тус улсыг улам хаалттай, мөн авторитар дэглэмийг бэхжүүлэхэд улам дэм болсон. Мөн тус орны батлан хамгаалах чадавхи нь ч эрс суларсан байна. Тиймээс ч ардчилсан Монгол Улсын хувьд туршлага судлах улс биш юм. Энэ бол өргөн утгаараа олон улсын нэр хүндийн асуудалтай ч холбогдоно.

Эдийн засгийн талаар байнга төвийг сахих нь даяаршлын үед бүрч байж таарахгүй, боломж ч байхгүй юм. Байнга төвийг сахисанаар эдийн засаг үсрэнгүй хөгжиж, хөрөнгө оруулалт цугтан орж ирэхгүй. Харин нээлттэй эдийн засаг, үр ашигтай эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа, технологийн дэвшил, тогтвортой, эрхзүйт, ардчилсан засаглал, ойлгомжтой, тогтвортой эрхзүйн орчин, шинжлэх ухаанд суурилсан эдийн засгийн бодлого Монгол Улсыг хөгжүүлнэ. Эдийн засгийн шинжлэх ухаанд үр ашиг бүхий хөгжлийн загвар, эдийн засгийн өсөлтийн үр дүнг хэзээч төвийг сахих статустай холбон тайлбарлаж байгаагүй юм.

Байнга төвийг сахисанаар Монгол Улс энхийн зууч хийх, олон улсын банк, санхүүгийн төв, Женев лугаа олон улсын байгууллагууд төвлөрөх цэг болно гэдэг нь ч үндэслэлгүй юм. Эдүгээ нэг улс дангаараа энхийн зуучлал хийх боломж амжилт багатай болсон. Харин P5+1, зургаан талт хэлэлцээ, НҮБ, ЕАБХАБ-ын зуучлал илүү нэр хүндтэй байна. Кени улс бол төвийг сахисан статусгүй, хөгжиж буй орны жишээ бөгөөд энд НҮБ-ын системийн болон төрөлжсөн статустай олон улсын 30 гаруй байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Тайландын вант улс мөн нэгэн адил болно.

Монгол Улс хоёр хөрштэйгөө харилцах асуудал гадаад бодлогын тэргүүлэх чиглэл гэдгийг онцолж, стратегийн түншлэлийн харилцааны эрхзүйн үндсийг баттай тавьж, улс төрийн хувьд бүхэлдээ тэнцвэртэй харилцаж байна. Монгол Улс гурван хөршийн саммитыг санаачлан хэрэгжүүлж, энэ нь цаашдаа байнгын механизм болон төлөвших төлөвтэй. Өөрөөр хэлбэл гурван улсын харилцаа шинэ агуулга, хэлбэрээр баяжин урагшилж байгаа билээ. Нөгөө талд Орос-Хятадын харилцаа стратегийн иж бүрэн түншлэлийн түвшинд хүрсэн нь манай гадаад хамгийн ойр орчин сайн байна гэсэн үг. БНХАУ Хятад-Оросын харилцаа хэзээ ч холбоотны харилцаанд эргэж очихгүй гэж мэдэгдсэн билээ. Иймд өнөө болон ойрх ирээдүйн Монгол Улсын геополитикийн хамгийн ойр орчинд дайн гарах магадлал тун бага байгаа юм. Ер нь бол байнга төвийг сахих статусыг хуульчлан зарлана гэдэг нь хөрш гүрнүүддээ итгэхгүй байна гэсэн үг. Монгол Улсад ямар нэг хэлбрээр аюул занал учруулаагүй байхад гэнэт байнга төвийг сахих тухай яриад эхлэнэ гэдэг үнэндээ бол хоёр хөрш орон Монголыг хавчиж дарамтлаад байгаа юм шиг ойлголтыг дэлхий нийтэд түгээж хөрш орнуудаа эвгүй байдалд оруулж буй хэрэг юм. Энэ нь алсдаа сөрөг үр дагавартай байж болохыг үгүйсгэхгүй.

Байнга төвийг сахисан орон өөрийгөө хамгаалах, батлан хамгаалах хүчинтэй байх онцгой эрхтэй гэсэн үндэслэл багатай тайлбар хийдэг. Төвийг сахих, эс сахихаас үл хамаараад аль ч улс өөрийгөө хамгаалах, батлан хамгаалах хүчинтэй байх онцгой эрхтэй.

“Төвийг сахих статусыг хэрэгжүүлэгч улс оронд нь тухайн бодлогоо засварлах, шинэчлэх, зогсоох онцгой бүрэн эрх хадгалагддаг” гэдэг нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, эрхзүйн орчин тогтворгүй байдгийг л нотлон харуулна. **Гадаад бодлогоор туршилт явуулж болохгүй.**

**Туршлага судалж байнга төвийг сахихгүй.** Ямар гадаад бодлого шийтгэн явуулах нь тухайн улсын онцгой бүрэн эрхийн асуудал мөн боловч олон улсын харилцааны хөгжлийн шинэ чиг хандлага, их гүрнүүдийн геополитик, байр суурийг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай байдаг. Гэхдээ олон улсын харилцаа, дипломатын түүхэнд ямар ч улс гүрэн гадаад бодлогоо шийтгэн явуулахдаа бусад улсын гадаад бодлогын туршлагыг судалж гадаад бодлогоо эрхлэн явуулж байгаагүй юм.

Байнга төвийг сахих бодлого нь олон тулгуурт гадаад бодлогын зарчимтай зөрчилддөг бөгөөд Монгол Улс байнга төвийг сахих бодлого явуулснаар “гуравдагч хөрш”-ийн бодлогод ямар эрсдэл, сорилт тулгарах тухайд судалгаа, дүн шинжилгээ алга байна. Байнга төвийг сахих статус Монгол Улсын “стратегийн түншлэл”, “иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцааг ямар нэг байдлаар хөндөх нь тодорхой. Зарим судлаачид холбоотны харилцааны ХХI зууны өөрчлөгдсөн хэлбэр нь *стратегийн түншлэл* гэж бичсэн нь ч буй. Тодорхой улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг нь дээрхтэй холбоотой болов уу. “Стратегийн түншлэл”-д улс төр-аюулгүй байдал, батлан хамгаалах, энхтайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр, хүний эрх, эрх чөлөө, ардчилалын асуудал гол төлөв тусгагдсан байдгаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд тогтвортой үргэлжилнэ гэсэн санаа хамт явж байдаг байна. Өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Стратегийн түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн бөгөөд гүнзгий юм.

Олон улсын эрхзүйд олон улсын гэрээнд нэг талын тайлбар хийх, гэрээний зүйл заалтуудыг төсөөтэй хэрэглэхийг хориглосон байдаг. Зарим судлаач 1993 оны Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний 4 дүгээр зүйл, 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээний мөнхүү 4 дүгээр зүйлийг эшлэн тайлбар хийхдээ: “хоёр хөрш олон улсын маргаан, зэвсэгт мөргөлдөөний үед Монголоор төвийг сахиулж, өөрийнхөө эсрэг хандуулахгүй байх гэсэн байр сууриаа энд суулгаж өгсөн нь харагдана. Төвийг сахисан Монгол байгаасай гэсэн хүсэл нь тэр үед тэгж илэрсэн хэрэг” хэмээн дураараа тайлбарласан байна.<sup>11</sup> Угтаа дээрх гэрээнүүдэд төвийг сахих тухай ганц ч өгүүлбэр ороогүй юм.

Хоёр хөршийн судлаачид Монгол Улсын байнга төвийг сахих санаачилгыг АНУ-ын заавраар хийгдэж үйлдэл байж магад хэмээн болгоомжилсон дүгнэлт хийх хандлага ажиглагдаж байгаа нь анхаарах асуудал мөн.

<sup>11</sup> Д.Баярхүү. “Төвийг сахих тухай дахин өгүүлэх нь” news.mn, baabar.mn 2016.04.08

Даяаршил, олон туйлт дэлхийн шинэ дэг журам төлөвших үйл явцад одоогийн Монгол Улсын гадаад бодлогод байнга төвийг сахих ямар ч тулгам шаардлага байхгүй, ингэхлээрээ одоогийн гадаад бодлогоо улам идэвхжүүлэх шаардлагатай юм.

Монгол Улс идэвхтэй гадаад бодлого явуулснаар бүс нутгийн төдийгүй дэлхийн энхтайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлнэ. Идэвхтэй гадаад бодлого өөрөө батлан хамгаалах чухал арга хэрэгсэл болдог.

Монгол Улсын геополитикийн хамгийн ойр орчинд бидний оролцох дайн гарах магадлал бага, энхийн цагт гишүүнээр элсэх цэргийн эвсэл холбоо байхгүй.

Даяаршлын эрин үе, XXI зуунд жижиг улсын гадаад бодлого илүү прагматик, олон улсын эрхзүйн үүднээс императив буюу хатуу бус, харин илүү диспозитив буюу уян хатан, идэвхтэй, манёвр хийх чадвар сайтай, нээлттэй, тууштай, олон хэмжээст, сюрприз багатай, тогтвортой, олон туйлт дэлхийн шинэ дэг журамд дасан зохицож, идэвхтэй тоглогч байх ёстой.

*Эцэст нь* Монгол Улсын санаачилгын тухайд хоёр хөрш болон “гуравдагч хөрш”-ийн хандлагын талаар хэдэн зүйл хэлье.

ОХУ-ын хувьд Монгол Улсын санаачилга хоёр улсын стратегийн түншлэл, түүний цаашдын хөгжил, түүхэн хугацаанд тогтсон онцгой харилцааны мөн чанарт хэрхэн нийцэх, түүнчлэн тусламжид үндэслэсэн цэрэг-техникийн хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлөх зэрэг асуудлыг хөндөж байгаа нь тодорхой.

БНХАУ-ын хувьд байнга төвийг сахих санаачилга нь бүс нутгийн энхтайван, тогтвортой байдал, харилцан итгэлцэлд тустай байх, хоёр тал аливаа бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх өнцгөөс харах, аль аль талдаа ялгаагүй чухал учир хариуцлагатай судлан нарийн судалгаа хийхэд хугацаа хэрэгтэй байгааг тэмдэглэж байгаа болов уу.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Керри 2016 оны 6 дугаар сарын 5-нд Монголд Улсад нэг өдрийн айлчлал хийсэн билээ. Тэрбээр Монгол Улсыг ардчилал, хүний эрх харьцангуй хязгаарлагдмал, чөлөөт хэвлэл хяналттай, авторитет дэглэмтэй

хоёр хөрштэй нь харьцуулаад үлгэр жишээ болохуйц “ардчилалын баянбүрд” (oasis of democracy)<sup>12</sup> хэмээн онцолсон нь Монгол Улс ардчилалын оройд гарчихсан гэсэн үг биш нь мэдээж билээ. Жон Керри айлчлалын үеэр Шангри-Ла зочид буудалд монголын залуу манлайлагч нарын төлөөлөлтэй уулзаж харилцан ярилцсан нь анхаарал татав. Ярилцлагын үеэр залуус Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан Монгол Улс төвийг сахих бодлогын тухайд АНУ-ын санаа бодол ямар байгааг сонирхжээ. Жон Керри хариулахдаа: “Тиймээ, Төвийг сахина гэж чухам юуг хэлж байгаагаас (олон зүйл) хамаарна. Өөрөөр хэлбэл, юуны учир, ямар зүйлийн талаар та төвийг сахих вэ гэдгээс л хамаарна гэсэн үг юм. Хүний эрхийн талаар би та бүгдийг битгий төвийг сахиасай гэж хүсэх байна. Ардчиллын тухайд би та бүхнийг битгий төвийг сахиасай гэж хүсч байна. Гэхдээ, хэрэв та бүхэн хэсэг бүлэг улс хоорондын тодорхой сөргөлдөөний тухайд төвийг сахих гэж байгаа бол хүний гараар могой бариулах маягийн зарим нэг зүйл рүү чирэгдэн орох шаардлагагүй. Энэ нь төвийг сахих гэж чухам юуг хэлэхээс хамаарна. Миний бодлоор хэн байсан билээ дээ? Данте (Дундад зууны үеийн Италийн гүн ухаанч, яруу найрагчийг хэлсэн болов уу Д.У) бичиж байсан шиг санагдаж байна. Аугаа их ёс суртахууны хямралын үед гол нь төвийг сахиж амиа хойхоолоод тээнэгэлзэн суусан тэдгээр хүмүүс тамын тогооны хамгийн халуун бугшсан ангал руу ордог тухай өгүүлсэн байдаг. Зөв биз? Өнөөдөр та бүхэн тамд итгэхгүй байж болно, та бүхэн диваажинд итгэхгүй байж болно, ер нь юунд ч итгэхгүй байж болно. Харин цэвэр ёс суртахууны асуудлуудын үүднээс авч үзвэл та бүхэн ёс суртахууны луужинтай байх хэрэгтэй нь ойлгомжтой болов уу. Тиймээс хэрэв та ёс суртахууны луужингаа алдвал та бүхэн улс орноо алдана, та эдлэх эрхээ алдана, та эрх чөлөөгөө алдах хамгийн их эрсдэлтэй. Учир иймээс хаана төвийг сахих, төвийг сахихыг хэрхэн ойлгож тодорхойлохоос үүдэн болгоомжтой хандаасай гэж хэлмээр байна.

Бас нэг жишээг та бүхэнд товч хэлье. Асад Сирид ард түмнийхээ талаар явуулж буй үйлдлийг хараад ямар ч улс төвийг сахина гэж би бодохгүй байна. Энэ бол нэг жишээ юм. Төрлөөр устгахын тухайд

---

12 “US Secretary of State John Kerry hails Mongolia as «oasis of democracy» in tough neighbourhood”- The Straits Times. Asia. June 5, 2016

ч хэн ч төвийг сахиж чадахгүй байх гэж бодож байна. Цэрэгжсэн хүүхдүүдийн тухайд ч хэн нэгэн төвийг сахиж чадахгүй. Хүний наймааны тухайд ч мөн адил хэн ч төвийг сахиж чадахгүй болов уу. Үүнийг л би ёс суртахууны луужин баримжаа гээд байгаа юм шүү дээ. Эдгээр зүйлсийн тухайд ямар нэг мэдрэмж төрөх нь хүний ухамсрын зүй ёсны хэрэгцээ шаардлага байхад эдгээр зүй бус үйлдлүүдийн талаар санаа бодлоо илэрхийлэхгүй, ёс суртахууны луужин баримжаагаа барихгүй харин ч холдуулаад амьдралдаа зүгээр л мөрөө хөөгөөд явж болохгүй биздээ»<sup>13</sup> гэсэн байна.

---

13 Secretary Kerry's Conversation With Young Leaders, Remarks John Kerry Secretary of State, Shangri La Hotel, Ulaanbaatar.: Mongolia, June 5, 2016, Embassy of the US, Ulaanbaatar.: Mongolia